



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

“Хужиртайнбулгийн ундарга” ХЗХ-нд тусгай зөвшөөрөл болон төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 4.1 дэх хэсэг, Хорооны 2012 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам”-ын 1.2, 1.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хужиртайнбулгийн ундарга" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Тус ХЗХ-нд төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрсүгэй.
3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг "Хужиртайнбулгийн ундарга" ХЗХ /Д.Очирпүрэв/-нд үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000576